

Жишээ ба дадлага

3 Нифай 14-ийг зааж байхдаа ашиглаж болох эхний эгнээнд байгаа сургаал эсвэл зарчмын асуулт, тайлбарын жишээг судал. Бусад эгнээнд доор дурдсан судрын эшлэлүүд дэх сургаал эсвэл зарчмын асуулт, тайлбарыг бичнэ үү.

3 Нифай 14:1-6	3 Нифай 14:7-11	3 Нифай 14:12-27
Хам сэдэв ба агуулгыг ойлгох		
<ul style="list-style-type: none"> 1-р шүлэгт гарсны дагуу Аврагчийн зааврын энэ хэсгийн сонсогчид нь хэн байсан бэ? Энэ нөхцөл байдал дахь сонсогчид хэн байсныг мэдэх нь юуг өөрчлөх вэ? 3–5-р шүлэгт цэдэглэснээр, энэхүү зүйрлэлд Аврагч ямар бодит юмсыг ашигласан бэ? Уг бодит юмс хаана байсан бэ? Яагаад Аврагч эдгээр тодорхой бодит юмсыг ашиглахаар сонгосон бэ? Бодит юмсын байрлал ямар ач холбогдолтой вэ? 		
Сургаал, зарчмуудыг олж тогтоох		
<ul style="list-style-type: none"> Аврагчийн зүйрлэлийн бидэнд зааж байгаа зарчим юу вэ? Зарчим: Хэрэв би бусдын алдаанд анхаарлаа хандуулбал өөрийн алдааг анзаарч харах боломжгүй байх болно. 		
Сургаал, зарчмуудыг ойлгох		
<ul style="list-style-type: none"> Бусдын сул талуудад анхаарлаа хандуулах нь өөрсдийн алдааг анзаарч харахад маань хэрхэн саад болдог вэ? 		
Сургаал, зарчмуудын үнэн ба ач холбогдлыг мэдрэх		
<ul style="list-style-type: none"> Та хэзээ хэн нэгнийг буруу шүүхээс татгалзснаар адислагдаж байсан бэ? 		
Сургаал, зарчмуудыг хэрэгжүүлэх		
<ul style="list-style-type: none"> Та өөрийн алдааг илүү сайн анзаарч харан, засах алхам хийхийн тулд нүдэн дэх “өргөсөө” авах ямар өөрчлөлтийг хийж болох вэ? 		

